



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Зөвлөмжийн дагуу авах арга хэмжээний тухай

Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 4.1.6-т заасныг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангахад цөмийн технологийн хэрэглээг эрчимжүүлэх, малыг эрүүлжүүлэх, ургамал хамгаалах, таримал ургамлын шинэ сорт гарган авах, хүнсний ногооны хадгалалтыг уртасгах, малын гаралтай экспортын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг хангах, ус шингээгч био-бордоо үйлдвэрлэх, мөн эмнэлгийн хэрэгслийг ариутгахад чиглэгдсэн судалгаа-хөгжүүлэлт-инновац, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах цацрагаар шарах төхөөрөмжийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг дүр орлон гүйцэтгэгч (С.Төгсдэлгэр) нарт чиглэл болгосугай.

2. Засгийн газрын 2022 оны 03 дугаарын сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн тайланг Засгийн газрын хуралдаанд оруулж, хэлэлцүүлэх ажилд дэмжлэг үзүүлэхийг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Тавинбэх), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Б.Бямбадагва), Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Д.Баттогтох) нарт чиглэл болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд үүрэг болгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
КОМИССЫН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЦӨМИЙН
ЭНЕРГИЙН КОМИССЫН ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАНД

Цөмийн энергийн комиссын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь”

“Бадрах Энержи” ХХК-ийн төслийн хөрөнгө оруулагч Орано майнинг компаниас ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төсөл”-ийн талаар;

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төсөл”-ийн талаар танилцуулгыг УУХҮЯ, ЭЗХЯ, ГХЯ, ХЗДХЯ-тай хамтран боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд оруулж танилцуулахыг ЦЭК-ын дарга Л.Энх-Амгаланд үүрэг болгов.” гэжээ.

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБА



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

“ГУРВАН САЙХАН” ХХК-НД

Цөмийн энергийн комиссын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь”

“Гурвансайхан” ХХК дахь төрийн хувь эзэмшлийг нэмэгдүүлэх” талаар;

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “БНЧУ-ын “Ураниум Индастри” ХК нь Канад Улсын “Дэнисон Майнс” корпорациас “Гурвансайхан” ХХК-ийн 85 хувийн хувьцааг авахдаа манай улсын хууль, тогтоомжийн дагуу татвар суутган тооцох татварын тайлан гаргаж, татвар төлөөгүй, мөн “Гурвансайхан” ХХК-ийн хууль тогтоомжийн хэрэгжилт, татварын тайлагнал, ногдуулалтын байдалд татварын албанаас эрсдэл тооцон 2018-2021 онуудад татварын тайлагнал, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийгдэх талаар Татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг үндэслэн “Гурвансайхан” ХХК дахь төрийн хувь эзэмшлийг нэмэгдүүлэх асуудлыг хяналт, шалгалт дууссаны дараа хэлэлцүүлэх нь зүйтэй” гэжээ.

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБА

